

EPCRC  
ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS  
RESEARCH CENTER  
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ  
ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

# САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

## 2023/09

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2023.IX	2022.IX	2023.VIII	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2023 оны 2-р улирал	их наяд ₮, оны үнээр	30.4	23.1	-	-	-	-	6.4% ▲
Инфляц	хувь	10.1	13.8	10	-0.2% ▼	-	6.5% ▲	-3.7 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин, 2023У2	хувь	7.8% 2022 оны У2	5.8% 2023 оны У2	-	-	-0.8% ▼ нэгж хувиар	-	-2.0% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	2158	-962	1818	340 ▲	-	-	3120 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3466.08	3257.10	3469.98	3.9 ▼	-	-	208.98 ▲
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	4540.7	2405	4057.0	484 ▲	-	-	2136 ▲
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	48.9	19	42.6	-13% ▼	-	-	2.6 дахин ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	1151.3	1093.4	1022.3	-2% ▼	-	-	5% ▼
Төв банкны бодлогын хүү	хувь	13%	12%	13%	0%	-	0%	1% ▲
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	4.1	2.8	3.93	5% ▲	-	-	48% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	8.43%	11.16%	8.59%	-0.16 нэгж хувиар ▼	-	-	-2.73 нэгж хувиар ▼

### ОНЦЛОХ СТАТИСТИК:

2024 оны төсвийн төсөөлөл	Төсвийн төсөөлөлд 2024 оны төсвийн төсөөллийг боловсруулахдаа эдийн засгийн өсөлт ирэх онд 7 хувьтай, инфляц 8.5 хувь байхаар төсөөлжээ. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ: 25.2 их наяд буюу ДНБ-ий 34.2%, Төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн: 27.3 их наяд буюу ДНБ-ий 37%, Төсвийн тэнцэл: -2.07 их наяд буюу ДНБ-ий -2.8%
8 дугаар сарын байдлаар 431,130 жуулчин Монгол Улсад иржээ.	Нийт 650 орчим сая ам.долларын орлогыг дотоодын эдийн засагт оруулаад байна. "Жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, Монгол орныг сурталчлах ажлын хүрээнд энэ оны 2, 4, 6 дугаар саруудад шууд нислэгтэй Япон, Солонгос, Хятад улсад "Welcome to Mongolia" арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:

Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Төв банкны бодлогын хүүг хэвээр үлдээв.	2024/9/15	Монголбанкны мөнгөний бодлогын хороо хуралдаж бодлогын хүүг 13 хувь хэвээр үлдээв.



[www.facebook.com/ecrcmn](http://www.facebook.com/ecrcmn)



[www.twitter.com/ursulduhchadvar](http://www.twitter.com/ursulduhchadvar)



[www.instagram.com/ecrcmn](http://www.instagram.com/ecrcmn)



[www.ecrc.mn](http://www.ecrc.mn)




976-11-321927

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### График


#### Нөлөөлөл

#### Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 9 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 10.1 хувь өсөв. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 9 дүгээр сард өмнөх сараас 0.2 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.4 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.3 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 0.1 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

#### Валютын ханш




Америк долларын ханш 2023 оны 9 дугаар сард 3466.008 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 208.98 төгрөгөөр суларч, өмнөх сараас 3.9 төгрөгөөр чангарсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 5%-иар, өнгөрсөн жилийн мөн үеэс 48%-иар тус тус өсөж, 4.1 тэрбум ам.долларт хүрээд байна.

#### Улсын төсөв



Татварын нийт орлого 2023 оны 9 дүгээр сард 2.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 774.5 (55.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татварын орлого 208.3 (60.2%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 91.4 (34.9%) тэрбум төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татвар 90.5 (24.0%) тэрбум төгрөг, бусад төрлийн татвар хураамжийн орлого 334.2 (2.8 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

#### Гадаад худалдаа



Монгол Улс 2023 оны эхний 9 сард нийт 158 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 18.1 тэрбум америк доллар, үүнээс экспорт 11.3 тэрбум америк доллар, импорт 6.8 тэрбум америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.8 (18.1%) тэрбум америк доллароор, экспорт 2.4 (26.6%) тэрбум америк доллароор, импорт 399.1 (6.3%) сая америк доллароор тус тус өсжээ. Харин 2023 оны 9 дүгээр сард экспорт өмнөх сараас 14.8 (1.1%) сая америк доллароор, импорт 114.2 (12.4%) сая америк доллароор тус тус буурсан байна.

#### Дэлхийн эдийн засагт

- Дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2022 онд 3.4 хувь байсан бол өсөлт 2023 онд 2.8 хувь болж буурч, 2024 онд 3.0 хувьд хүрэх төлөвтэй байна.  
**Эх сурвалж: Олон улсын валютын сан**
- Инфляц бүс нутгийн хэмжээнд 2023 онд 4.2%, 2024 онд 3.3% буурах төлөвтэй байгаа N<sup>0</sup>  
**Эх сурвалж: Азийн хөгжлийн банк, <https://ikon.mn/n/2tv5>**

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 9-р сар 2023 он, Үндэсний статистикийн хороо](#)
2. [Статистикийн бюллетень, 9-р сар 2023 он, Монголбанк](#)
3. [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)